

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 02 сарын 06-ны өдөр

Дугаар...

БА-043/2025

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 41 дүгээр хороонд баригдсан дунд төвөгшилтэй ангиллын зорьтой 4 давхар, 1 блок хүчин чадал бүхий төрийн захиргааны зориулалттай барилга байгууламжид Засгийн газрын 2021 оны 07 сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 14 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

- 2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2024/04/01 огноо, 0014718 дугаар, БАЗГ2024/0163
- 2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар ЕГ Шифр: ГАС-01/2023;
- 2.3. Захиалагч: Нийслэлийн Засаг даргын Тамгын газар оноосон нэр, 9011122089 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2659603 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Жанжин Д.Сүхбаатарын талбай 7, 11-325044 холбоо барих утас: www.ulaanbaatar.mn цахим хаяг;
Захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч: "Сонгинохайрхан дүүргийн захиалагчийн алба"ОНӨААТҮГ оноосон нэр, 9014001117 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5972833 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 27 дугаар хороо, СХД-ийн ЗДТГ-ын нэгдсэн байр, 70177989 холбоо барих утас, shdzaar@gmail.com цахим хаяг;
- 2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: Инерци ХХК оноосон нэр, 9011146144 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2694727 регистрийн дугаар, БУ11-618/20 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 6 дугаар хороо, Кёкүшю тауэр, 12 давхар, 1203 тоот, 99185029, 88881147 холбоо барих утас;
- 2.5. Барилгын ажлын түншлэн гүйцэтгэгч: Өсөх ингүүмэл констракшн ХХК оноосон нэр, 9011710144 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6262996 регистрийн дугаар, БУ16-291/23 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 16 дугаар хороо, 16 дугаар хороолол, ШШГЕГ 24Б байр, 3 тоот, 99107967 холбоо барих утас; оруулах комисс

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 16 дугаар хороо, 16 дугаар хороолол, ШШГЕГ 24Б байр, 3 тоот, 99107967 холбоо барих утас;

- 2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Грийн арт солюшн ХХК оноосон нэр, 9011777035 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6372465 регистрийн дугаар, ЗТ11-458/19 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 18 дугаар хороо, 4 дүгээр хороолол, 33 дугаар байр, 02 тоот, 99008271 холбоо барих утас;
- 2.7. Барилга байгууламжийн ашиглагч байгууллага: Нийслэлийн Засаг даргын Тамгын газар оноосон нэр, 9011122089 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2659603 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 23 дугаар хороо, Нийслэлийн Нутгийн захиргааны цогцолбор байр, 11-325044 холбоо барих утас; www.ulaanbaatar.mn цахим хаяг;
- 2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан.**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

- Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

- Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

- 3.1 Энэ дунд төвөгшилтэй ангиллын зорьтой 4 давхар, 1 блок хүчин чадал бүхий төрийн захиргааны зориулалттай барилгын байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:
Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

- 3.2 Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:
- а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивд, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад барилга байгууламжийг ашигласны үр дүнд барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах комиссоос ДҮГНЭСЭН нь:
 - б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар

болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3 Ашиглагч байгууллагад:

- а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;
- б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;
- в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4 Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 5 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 28 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1 Дунд төвөгшилтэй ангиллын зорьтой 4 давхар, 1 блок хүчин чадал бүхий төрийн захиргааны зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан.

Сонгинохайрхан дүүргийн 41 дүгээр хороо, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын захиалгатай, зорьтой 4 давхар, 1 блок төрийн захиргааны барилга

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч



(А.Мөнгөн)

Нарийн бичгийн дарга: "Сонгинохайрхан дүүргийн Захиалагчийн алба" ОНӨААТҮГ-ын Ерөнхий инженер



(Д.Энхтунгалаг)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 41 ДҮГЭЭР ХОРОО, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЗАХИАЛГАТАЙ, ЗООРЬТОЙ 4 ДАВХАР, 1 БЛОК
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ЗОРИУЛАЛТТАЙ БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ
КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 01 дугаар сарын 13

Улаанбаатар хот

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын захиалгатай, Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалттай, “Хороо өрхийн эмнэлэг цагдаагийн хэсгийн цогцолбор барилга /Сонгинохайрхан дүүрэг, 41 дүгээр хороо/ нь Төрийн захиргааны зориулалттай, зорьтой 4 давхар, 1 блок барилгыг ашиглалтад оруулах Улсын комиссын хуралдаан 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр 10:00 цагт уг барилгын 4 дүгээр давхрын 402 тоот өрөөнд 15 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 12:40 цагт дуусав.

Комиссын бүрэлдхүүн:

1. Комиссын дарга:

Хяналт шалгалтын газрын барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч



2. Комиссын нарийн бичгийн дарга:

Сонгинохайрхан дүүргийн “Захиалагчийн Алба”ОНӨААТҮГ-ын Ерөнхий инженер

Д.Энхтунгалаг

Комиссын гишүүд:

3. Нийслэлийн Хяналт Шалгалтын Газрын Барилга техникийн хяналтын Улсын ахлах байцаагч

Н.Ёндонсамбуу

4. Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Эрчим хүчний хяналтын Улсын байцаагч

Э.Цогзолмаа

5. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Техник хяналтын хэсгийн ахлагч

Ц.Билигт

6. Ус сувгийн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх Төвийн менежер

Г.Үүрийн-Гэгээ

7. Мэдээлэл холбоо сүлжээ ХХК-ийн Технологийн Удирдлага төлөвлөлтийн газрын Дэд бүтэц төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

М.Жаргалан

8. Нийслэлийн Онцгой байдлын газрын Гал түймэртэй тэмцэх хэлтсийн Барилгын зураг төслийн хяналтын байцаагч, хошууч

Б.Даваасүрэн

9. Барилгын Хөгжлийн Төвийн Барилгын материал, Үйлдвэрлэлийн хэлтсийн инженер

Г.Уртнасан

10. Үндэсний Төв Архив, Зураг төслийн баримтын ахлах архивч

Н.Өлзийжаргал

11. Ашиглагч: Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын Газрын Аж ахуйн тасгийн дарга

Б.Сумъяабазар

- | | |
|---|----------------------------|
| 12. Хөгжлийн бэрхшээлтэй Иргэний Эрхийг
Хамгаалах ТББайгууллагын төлөөлөгч | Б.Ганбаатар |
| 13. Зураг төсөл зохиогч: “Грийн арт солишн” ХХК-ийн
Захирал | О.Ганчимэг
М.Өлзийхутаг |
| 14. Гүйцэтгэгч: “Инерци” ХХК-ийн Захирал | |
| 15. Түншлэгч: “Өсөх Ингүүмэл Констракшн” ХХК-ийн
Захирал | Ж.Вычеслов |

КОМИССЫН ГИШҮҮДИЙН ИРЦИЙН БАЙДАЛ

- Мэдэгдэл хүлээн авсан – 15. Хуралд комиссын гишүүд 100%-ийн ирцтэй.
- Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 15.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын захиалгатай, Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалттай, “Хороо өрхийн эмнэлэг цагдаагийн хэсгийн цогцолбор барилга /Сонгинохайрхан дүүрэг, 41 дүгээр хороо/ -ыг барилга угсралтын ажлыг байнгын ашиглалтад оруулахад шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комиссын дарга хурлыг нээж, комиссын гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлтэй танилцан хянаад дараах саналуудыг гаргав.

Н.Ёндонсамбуу:

- Бетоны лабораторийн шинжилгээ үзүүлэх /+28 дээш хоногтой/;
- Лифтний албан шаардлага биелүүлэх;
- Өөрчлөлтийн зураг хийж баталгаажуулах;
- Ерөнхий төлөвлөгөөнд тайлбар албан тоот ирүүлэх;
- Барилгын тухай хуулийн дагуу баталгаа албан тоот ирүүлэх;
- Гонхны хэсгийг зурагт тусгагдсаны дагуу хийж гүйцээх;
- Зоорийн давхрын өрөөний тодорхойлолт тайлбар албан тоот ирүүлэх;

-Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Э.Цогзолмаа:

- Усны нөөцийн савыг шинжилгээнд хамруулж, дүгнэлт гаргуулах;
- Усны нөөцийн савны өрөөнд байгаа цахилгаан утаснуудыг цэгцэлж цэвэрлэх;
- Давхар бүрийн коллекторыг цэвэрлэж, хаягжуулах;
- Барилгын салхивч угсралтын ил, далд ажлын актыг бүрэн баталгаажуулж шалгуулах;

-Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Г.Уртнасан:

- Барилгын тухай хуулийн 5.7.1-д заасан норм, нормативын сангийн төлбөрийг төлөх;
- Ариун цэврийн өрөөнүүдийн тусгаарлах кабин хийх;
- Өөрчлөлтийн зураг төсөл баталгаажуулах, зохиогчийн нэгдсэн дүгнэлтэд тусгах;
- 1-р давхрын гонх, гадна хаалга батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгэх;

Барилг

- Суурийн улны түвшинд ус илэрсэн. Авсан арга хэмжээ, ил далд ажлын акт шалгуулах;
- Бараа материалын тохирлын гэрчилгээ нөхөж үзүүлэх;

-Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Б.Ганбаатар:

- Нийтийн авто зогсоолд ХБХ-н машинд зориулан зогсоолын өргөн 3м95см машин зогсох зай, 2м45см тэргэнцэртэй хүн бууж суух зай1.5м байхаар эрээн шугам татаж тусгаарлаж өгнө. Зогсоолын урд 1.8м шон, 60х60 самбар байрлуулна;
- Зогсоолоос явган хүний замруу гарах брожурт налуулга хийх;
- Гадна налуу замыг стандартын болгох, 2 талын бариулыг 70см өндөр болгох;
- Цагдаагийн газрын ариун цэврийн өрөөний угаалтуур, суултуур, хорооны байрны 1-4-р давхарын ариун цэврийн өрөөний угаалтуур, суултуурыг БНБД31-29-22 стандартын дагуу туслах бариулыг суурилуулах;

-Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Г.Үүрийнгэгээ:

- Гүний худгийн шугам дээр тоолуур суурилуулах, холбогдох бичиг баримтыг бүрдүүлэх, гэрээ хийх;
- Ундны уснаас сорьц өгч дүгнэлтийг шалгуулах;
- Бохир усны цооногийн хийцлэл өөрчилсөн талаар зохиогчийн дүгнэлт шалгуулах;
- Гадна цэвэр бохир усны шугамын ил далд ажлын акт шалгуулах;

-Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Ц.Билигт

- УБЦТХ ТӨХК-ийн шинэ хэрэглэгчийн сүлээнд залгах зөвшөөрлийн бичиг;
- Дизель генераторыг АЗБТ-д бүртгүүлэх;
- Б1 болон 1-р давхрын гүйцэтгэлийн зураг;
- Аваарын самбарыг зургийн дагуу тоолуур суурилуулах;
- Аянгын хүрээг зургийн дагуу гүйцэтгэх;
- Давхрын самбар, ерөнхий самбарт бирк, схем, хаяг, плакат хийх;
- Дизель генератор хүлээлцэх акт үйлдэх;

-Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

М.Жаргалан:

- Шинээр суурьлуулсан холбооны агаарын багануудыг дугаарлах;
- Холбоо дохиоллын гүйцэтгэлийн актыг шинэчлэх, дахин үйлдэх;
- Техникийн өрөөнд тусгаарлалт хийх;

-Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Б.Даваасүрэн:

- Гадна дулаалгын дүгнэлт шалгуулах;
- Өөрчлөлтийн зураг оруулах;

- Галын гидрантын холбох тотго/хятад байгааг орос болгох/ солих, тэмдэглэгээ байрлуулах, ус тавьж шалгах;
- Галын дохиоллын систем батлагдсан зургийн дагуу хийх, шалгасан акт, фото зураг, хамгаалах таг авах, удирдлагын самбар 24 цагаар байрлах өрөөнд байрлуулах, зааварчилгаа;
- Гал унтраах анхан шатны багаж зэвсэглэмж байрлуулах, MNS5566:2020 стандартын дагуу;
- Цахилгаан шатны өрөө тусгаарлах, металл хаалга төлөвлөх, гал унтраах автомат модулын систем төлөвлөх;
- 4-р давхарт хаалга онгойх хэсэгт давхардаж байгааг засварлах;
- Аваарын гарц хаалга давхардсан. Шууд буухаар төлөвлөх;

-Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Б.Сумъяабазар:

- Агааржуулалт дагасан цэвэр усны босоо шугамыг дулаалах;
- Давхаруудад 3,4 гэрэл таллаж шатсан;
- 1-р давхарт кроп дутуу;
- Цахилгаан тоолуур баталгаажуулалт хийж, зургийг ЗДТГ-т хүлээлгэн өгөх;
- УБЦТС ТӨХК болон бусад байгууллагатай үлдэгдэл төлбөргүй хүлээлгэн өгөх;
- Ариун цэврийн өрөөнд хана, хаалт хийх /эр эм тэмдэглэгээтэй/;
- Вакум цонхны тохиргоо хийх;
- Дизель генератор УБЦТС ТӨХК-д бүртгүүлэх;
- Цахилгаан дулааны тохируулгын ажлыг дахин хийх;

-Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Н.Өлзийжаргал:

- Хувийн хэрэгт газрын гэрээ, гэрчилгээ, кадастрын зураг, газрын төлбөр тооцоо нийлсэн акт, зохиогчийн гэрээ, усны шинжилгээ, зохиогч, захиалагчийн дүгнэлт, чанарын баталгааг хавсаргах;
- Гэрэл зурагт тайлбар бичих;
- Журнал баталгаажуулах;
- Баримтыг архивт баримт хүлээлгэж өгөх нийтлэг жагсаалтын дагуу бүрэн бүрдэлтэй бүрдүүлж, цоолж, нуруулдаж, бичвэртэй хуудас бүрийг дугаарлан, дотоод товъёог үйлдэх;
- Ажлын зураг болон холбогдох баримтын эх хувийг архивт хүлээлгэн өгөх;

-Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

О.Ганчимэг:

- Батлагдсан зургийн дагуу 1-р давхарт гонхыг хийж гүйцээх;
- Давхаруудын ариун цэврийн өрөөнд суултуур тусгаарлах хаалт хийх;
- 2-р давхрын №7 өрөөнд крантны доор хийгдсэн решотка тагийг төмөр тагаар солих;

-Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Д.Энхтунгалаг:

- Зургийн өөрчлөлтийг баталгаажуулснаар хавсаргах;
- Гадна холбооны ажлыг хүлээлцсэн комиссын актыг дагуу ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөх, эцсийн хэрэглэгч уялдах;
- Ашиглагчид гадна бохир усны цооногийг хүлээлцэх;
- 8 камерийг ашиглагчид хүлээлцэх;
- Лифтний ашиглалт хариуцах байгууллагыг ашиглагч СХД, ЗДТГ-ын Аж ахуйн тасагтай холбож өгч, лифтийг хүлээлцүүлэх;
- Лифтний дүгнэлтийг бичиг баримтанд хавсаргах;
- Ариун цэврийн өрөөнд тусгаарлах хана, хаалт хийх;

-Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

М.Өлзийхутаг:

- Гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

А.Мөнгөн:

- Барилгын тухай хуулийн 14.3, 14.6 заалтын дагуу барилгад чанарын баталгаа гаргаж албан тоотоор ирүүлэх;
- Гадна ногоон байгууламжийг хийж гүйцээх хугацаа заасан баталгаа албан тоот ирүүлэх;
- Хашаа, хайсыг зэврэлтээс хамгаалах зориулалтын таг хийж, фото зургаар баталгаажуулан ирүүлэх;

-Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын захиалгатай, Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалттай, "Хороо өрхийн эмнэлэг цагдаагийн хэсгийн цогцолбор барилга /Сонгинохайрхан дүүрэг, 41 дүгээр хороо/ нь Төрийн захиргааны зориулалттай, зорьтой 4 давхар, 1 блок барилгыг ашиглалтад оруулах Улсын комиссын гишүүдээс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангуулан, үүрэг даалгаврын биелэлтээр комиссын дүгнэлт үйлдэх, баталгаажуулах, барилгыг байнгын ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын,
Барилга байгууламжийн ашиглалт,
Бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

"Сонгинохайрхан дүүргийн Захиалагчийн
Алба" ОНӨААТҮГ-ын Ерөнхий инженер



(А.Мөнгөн)

ганд



(Д.Энхтунгалаг)